



**“ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖУУЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ” ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ УЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар A/03

Дорноговь аймаг, Замын-Үүд сум

Г Ажилласан жилийн нэмэгдэл болон
мэргэшлийнзэргийн нэмэгдэл олгох журам батлах тухай


Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйл, Газрын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨААТҮГ-ын “Ажилласан жилийн нэмэгдэл болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалтыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. “Ажилласан жилийн нэмэгдэл болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер /Т.Мөнхзаяа/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Дэлгэрдалай/, Хуулийн зөвлөх, дотоод аудит /Д.Батчимэг/ нарт даалгасугай.

ЗАХИРАЛ

Г.ГАНСҮХ

0471220003



АЖИЛЛАСАН ЖИЛИЙН НЭМЭГДЭЛ БОЛОН
МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ
ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 “ШТШАБ” ТӨААТҮГ-ЫН ажиллагсдын хөдөлмөрийн бүтээмж, идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллуулах зорилгоор Хөдөлмөрийн тухай хуулийн 108, 109 дүгээр зүйлд заасан үндэслэлээр нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг энэхүү журмын дагуу зохицуулна.

1.2 Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч нийт ажиллагсадад хамаарна.

ХОЁР. АЖИЛЛАСАН ЖИЛИЙН НЭМЭГДЭЛ
ОЛГОХ

2.1. Ажилласан жилийн нэмэгдэл хөлсийг олгоходоо ажилласан нийт хугацааг оруулан тооцно.

2.2. Ажилласан жилийн нэмэгдэл хөлсийг олгоходоо ажилласан жилээс хамааруулан шаталтай олгох ба үндсэн цалингаас тооцож олгох ба Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндсэлэн тооцно. Үүнд:

Д/д	Ажилласан жил	Олгох хувь	Тайлбар
1	6 – 10 жил	5 хувь	6 дахь жилийн эхний хоногоос 10 дахь жилийг дуустал
2	11 – 15 жил	10 хувь	11 дэх жилийн эхний хоногоос 15 дахь жилийг дуустал
3	16 – 20 жил	15 хувь	16 дахь жилийн эхний хоногоос 20 дахь жилийг дуустал
4	21 – 25 жил	20 хувь	21 дэх жилийн эхний хоногоос 25 дахь жилийг дуустал
5	26 – аас дээш жил	25 хувь	26 дахь жилийн эхний хоногоос

ГУРАВ. МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ
ОЛГОХ

3.1. Ажилтануудын мэргэшлийн зэргийн нэмэгдлийг тухайн ажлын байранд нийцэж буй эсэхээс шалтгаалж олгоно.

- 3.2. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгоходоо үндсэн цалингаас дараах хувиар тооцож олгоно. Үүнд:
- Зөвлөх инженер – 20 хувь
 - Мэргэшсэн инженер, мэргэшсэн нягтлан бодогч – 15 хувь